БАТЛАВ: АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Л.ГАНБОЛД

## СУМДЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДАД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ, ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХАМТАРСАН БАГИЙН УДИРДАМЖ

**Зорилго:** "Төсвийн тухай хууль" түүнийг дагаж гарсан журам зааврын хэрэгжилтийг бүрэн хангуулах, сумдын санхүүгийн үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлийг бууруулах, салбарын байгууллагын хариуцлага хамтын ажиллагааг сайжруулах, төсөвт байгууллагын төсөв захиран зарцуулалтын үр дүнг дээшлүүлэх.

**Зорилт:**

1. Хууль журмын хэрэгжилтийг хангуулах, хууль журмыг сурталчилан таниулах
2. Гарч болзошгүй аливаа эрсдэлийг бууруулах
3. Хамтарсан багийн дүгнэлт гаргаж зөвлөн туслах үйлчилгээг сумын нийт төсөв захирагч, нягтлан бодогч нарт үзүүлэх
4. Төсвийн хэмнэлт гаргах

**Хяналт хийх багийн бүрэлдэхүүн:**

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн дотоод хяналт
2. Санхүүгийн хяналт, аудитын алба
3. Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн удирдлагын хэлтэс
4. Боловсрол соёл, урлагын газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс

**Зохион байгуулалт:**

- Тус удирдамжийн дагуу хяналт хийж буй баг нь салбар салбарын хяналтыг хийх агуулгын хүрээнд тусгайлсан удирдамжтай байх ба удирдамжийн дагуу хэрэгжүүлэн ажилласан ажлын тайлан мэдээллийг бэлтгэн нэгдсэн хурал хийж сумдын удирдлагууд болон санхүүгийн ажиллагсдад тайлагнаж, заавар зөвлөмжийг өгч ажиллана.
- Шалгалтын хамтарсан багийн явах автомашиныг хуваарийн дагуу байгууллагууд гаргаж явах ба автомашин гаргаж буй байгууллага нь шатахууныг бүрэн хариуцна. Албан хаагчдын албан томилолтыг тухайн байгууллага хариуцна.

**Хяналт хийх агуулга:**

| № | Агуулга | Хамрах хүрээ | Хариуцах эзэн |
|---|---|---|---|
| 1 | - Төсвийн тухай хуулийн 36.6-д заасны дагуу сумын төрийн сангийн нэгжид дотоод хяналтыг хэрэгжүүлэх<br>/ Аймгийн Засаг даргын 2017 оны А/29 дүгээр захирамжийн дагуу хяналтыг хэрэгжүүлэх. / | Сумын төрийн сангийн нэгж | Санхүү, төрийн сангийн хэлтэс төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Б.Цэлмэгтуяа |
| 2 | - Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл<br>- Төсөвт байгууллагуудын дотоод хяналтын ажлын гүйцэтгэлт хийх аудит<br>- Хүний нөөц<br>- Орон нутгийн орлого<br>- Өмнөх шалгалтын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт | Сумын ТЕЗ-ийн багцын байгууллага, сумын санхүүгийн алба. Орон нутгийн байгууллага | Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны санхүүгийн хяналтын улсын байцаагч |
| 3 | - НЭМ-ийн чиглэлээр хэрэгжиж хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлын хяналт<br>- Санхүүгийн баримтын хяналт | Сумын Эрүүл мэндийн байгууллага | Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн удирдлагын хэлтсийн дарга Б.Батчимэг |
| 4 | - Боловсролын салбарын байгууллагын санхүүгийн хяналт<br>- Соёлын байгууллагын санхүүгийн хяналт | ЕБСургууль, Цэцэрлэг, Соёлын төв | Боловсрол соёл урлагын газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн Төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Далайжаргал |